


Хураангуй мэдээлэл:

- Банкуудын нийт зээлийн үлдэгдэл 2017 оны 8 дугаар сарын байдлаар 13.2 их наяд төгрөгт хүрснээс 79.5 хувь нь төгрөгийн зээл байна.
- Тайлант сард шинээр 1.4 их наяд төгрөгийн зээл олгогдсоны 76.4 хувь нь төгрөгийн зээл байна. Харин 1.2 их наяд төгрөгийн зээл төлөгдөв.
- Нийт зээлийн үлдэгдлийн 7.1 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 8.9 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна. Усан хангамж; бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл 45.3 хувь, уул уурхай олборлолт 25.8 хувь, боловсруулах үйлдвэр 17.6 хувь, барилгын салбар 10.9 хувь, худалдааны салбар 9.7 хувьтай байна.
- Нийт хэвийн зээлийн үлдэгдлийн 60.3 хувийг 1-5 жилийн хугацаатай зээл, 22.1 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл, 17.4 хувийг 1 жил хүртэлх хугацаатай зээл бүрдүүлж байна. Харин нийт олгосон зээлийн 41.8 хувь нь 1 жил хүртэл хугацаатай, 45.6 хувь нь 1-5 жил хүртэл хугацаатай, 12.6 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.
- Нийт зээлийн үлдэгдлийн 51.0 хувийг хувийн хэвшилд, 48.2 хувийг иргэдийн зээл эзэлж байна. Тухайн сард олгосон зээл өмнөх оны мөн үеэс 27.5 хувиар өссөнөөс хувийн хэвшилд олгосон зээл 28.7 хувиар, иргэдэд олгосон зээл 38.6 хувиар тус тус өсчээ.
- Банкууд 2017 оны 8 дугаар сарын байдлаар 47.6 мянган ЖДҮ эрхлэгчдэд олгосон 2.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.
- Тухайн сард ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН-үүдэд 115.4 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар жилийн 17.7 хувийн хүүтэй, 2.2 жилийн хугацаатай, иргэдэд 137.7 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар жилийн 21.4 хувийн хүүтэй, 1.3 жилийн хугацаатай олгожээ.


Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өсч 13 их наяд 160 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнээс *татан буугдсан*¹ банкуудын зээлийн үлдэгдлийг хасч тооцвол 12 их наяд 962 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин банкуудаас *Монголын Ипотекийн Корпорацид*

Зураг 1. Зээлийн үлдэгдэл



*шилжүүлсэн*² багцыг оруулж тооцвол нийт зээлийн үлдэгдэл 15 их наяд 557 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.1 хувийн өсөлттэй байна.

Зураг 2. Зээлийн үлдэгдэл /валютаар/




Нийт зээлийн үлдэгдлийн 79.5 хувь нь төгрөгийн, 20.5 хувь нь валютаар олгогдсон зээл байна. Санхүү даатгал, боловсрол, мэргэжлийн, шинжлэх ухаан, мэдээлэл холбооны салбарт валютын зээл давамгайлж байгаа бусад салбарт төгрөгөөр олгосон зээл давамгайлж байна.

¹ Зоос, Хадгаламж банк.


² МИК-д шилжүүлсэн 2.41 их наяд төгрөгийн зээлийн дүн нь банкны салбарын үзүүлэлтээс хасагдаж, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтэд тусгагддаг.

Зураг 3. Зээлийн үлдэгдэл /салбараар/



Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар нь авч үзвэл нийт зээлийн үлдэгдлийн 25.6 хувийг хэрэглээний, цалин болон тэтгэврийн зээл, 14.7 хувийг үл хөдлөх хөрөнгийн³, 13.1 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 10.5 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн, 9 хувийг барилгын салбарын, 20.3 хувийг бусад салбарын зээл тус тус эзэлж байна.

Зураг 4. Олгосон, төлөгдсөн зээл



Тайлант сард банкууд нийт 1.4 их наяд төгрөгийн зээл шинээр олгосон байна. Олгосон зээл өмнөх сараас 492.6 тэрбум төгрөгөөр буюу 51.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 8 дугаар сарын байдлаар нийт 1.2 их наяд төгрөгийн зээл төлөгдсөн бөгөөд өмнөх сартай харьцуулахад 32.5 хувиар өссөн байна.


Зураг 5. Олгосон зээл /төгрөг, валютаар/



Олгосон зээлийг валютаар нь авч үзвэл усан хангамж бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны зээлүүд 100 хувь төгрөгөөр олгогдсон байна.


³ МИК-д шилжүүлсэн орон сууцны ипотекийн зээлийг хассанаар

Зураг 6. Олгосон зээл /салбараар/




Тухайн сард шинээр олгосон зээлийг салбаруудаар ангилан авч үзвэл 31.7 хувийг хэрэглээ, цалин тэтгэврийн зээлд, 23.7 хувийг худалдааны салбарт, 6.7 хувийг санхүүгийн болон даатгалын, 5.2 хувийг уул уурхай олборлолт, 4.7 хувийг үл хөдлөх хөрөнгө, 3.9 хувийг барилгын, 3.2 хувийг боловсруулах үйлдвэрт, 2.5 хувийг хөдөө аж ахуйн салбарт тус тус олгожээ.

Зураг 7. Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Тайлант сард нийт олгосон зээлийн 41.8 хувийг 1 жил хүртэл хугацаатай зээл, 45.6 хувийг 1-5 жил хүртэл хугацааны зээл, 12.6 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.


Зураг 8. Хугацаа хэтэрсэн зээл /тухайн салбартаа эзлэх хувиар/



Хугацаа хэтэрсэн зээлийг гол салбаруудаар авч үзвэл уул уурхайн салбар 26.0 хувь, барилгын салбар 20.8 хувь, хөдөө аж ахуйн салбар 12.2 хувь, боловсруулах үйлдвэр 5.3 хувь, худалдааны салбарт 4.0 хувь, хэрэглээний зээл 2.0 хувьтай байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 8.9 байна Харин салбартаа эзлэх чанаргүй зээлийг авч үзвэл уул уурхайн салбарынх 25.8 хувь,

боловсруулах үйлдвэрийнх 17.6 хувь, барилгын салбарынх 10.9 хувь, худалдааны салбарынх 9.7 хувь, хөдөө аж ахуйн салбарынх 8.9 хувь, хэрэглээний зээлийнх 1.6 хувьтай байна.

Зураг 9 Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь /салбараар/



Харин салбаруудаар нь авч үзвэл усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл 45.3 хувь, уул уурхай олборлолт 25.8 хувь, боловсруулах үйлдвэрийнх 17.6, барилгын салбарынх 10.9 хувь, худалдааны салбарынх 9.7 хувьтай байна

Зураг 10. Эрсдэлийн сан болон чанаргүй зээлийн харьцаа



Банкууд чанаргүй зээлээс үүдэж гарах алдагдлаас хэр хамгаалагдсан байгаа эсэхийг тодорхойлдог нөөцийн хүрэлцээний харьцаа (provision coverage ratio)-г салбар бүрээр авч үзвэл захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа⁴, цахилгаан хий, уур, агааржуулалтын хангамж, боловсрол зэрэг салбарын зээл хүрэлцээтэй түвшинд байгаа бол хүний эрүүл мэнд, хөдөө аж ахуй, үл хөдлөх хөрөнгө, тээвэр ба агуулахын салбар дахь уг харьцаа бага байна.


Зураг 11. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл/ салбараар/



Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар буурч 6 их наяд 717 тэрбум төгрөгт, харин иргэдийн зээл 17.5 хувиар өсч 6 их наяд 342 тэрбум төгрөгт тус тус хүрэв. Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 20.0 хувь нь худалдааны салбарт, 19.9 хувь нь боловсруулах үйлдвэрт, 16.9 хувь нь барилгын салбарт 12.9 хувийг уул уурхай олборлолтын салбарт ногдож байна.

⁴ Захиргаа болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын эрсдэлийн сан ба чанаргүй зээлийн харьцаа 261.7 хувьтай байна. Зураг 11-т харуулаагүй болно.


Зураг 12. Иргэд, хувийн хэвшилд олгосон зээлийн жилийн өсөлт



МИК-д шилжүүлсэн зээлийн багцыг оруулж тооцвол иргэдийн зээл өмнөх оны мөн үеэс 15.5 хувиар өсчээ.


Иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд олгосон зээлийн тайлан

Зураг 13. Иргэдийн зээл /зориулалтаар/



Иргэдийн зээлийн үлдэгдлийн 27.5 хувь буюу 1 их наяд 742 тэрбум төгрөг ипотекийн, 31.2 хувь буюу 1 их наяд 979 тэрбум төгрөг цалингийн, 11.8 хувь буюу 747 тэрбум төгрөг жижиг дунд үйлдвэрийн, 10.9 хувь буюу 693 тэрбум төгрөг тэтгэврийн, 9.1 хувь буюу 575 тэрбум төгрөг хэрэглээний зээл байна.

Зураг 14. Иргэдийн чанаргүй зээлийн хувь /зориулалтаар/



Иргэдийн зээлийн үлдэгдлийн 3.5 хувийг чанаргүй зээл эзэлж байгаа бөгөөд салбартаа эзлэх чанаргүй зээлийг ангилан авч үзвэл ипотекийн зээлийн 3.4 хувь, цалингийн зээлийн 1.8 хувь, бусад зээлийн 1.8 хувь, хэрэглээний зээлийн 3.1 хувь, тэтгэврийн зээлийн 0.3 хувь нь чанаргүй зээл байна.


Тайлант сард иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 20.0 хувь, цалингийн зээл 20.0 хувь, хэрэглээний зээл 21.8 хувь, бусад зээл 21.0 хувь, тэтгэврийн зээл 17.8 хувьтай байна. Харин хугацаагаар нь авч үзвэл ипотекийн зээлийн дундаж хугацаа 17.7 жил,

Зураг 15. Иргэдийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа

	Зээлийн дундаж хүү /хувь/	Зээлийн дундаж хугацаа /сар/
Ипотекийн зээл	12.0	212.2
Хэрэглээний зээл	21.8	20.2
Цалингийн зээл	20.0	41.5
Тэтгэврийн зээл	17.8	7.3
Бусад зээл	21.0	11.4

цалингийн зээл 3.5 жил, бусад зээл 11.4 сар, хэрэглээний зээл 1.7 жил, тэтгэврийн зээлийн хугацаа 7.3 сарын хугацаатай байна.


Зураг 16. ЖДҮ-ийн зээл /олгосон салбараар/



Тайлант сарын эцсийн байдлаар ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 2 их наяд 180 тэрбум төгрөг байна. ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН-д олгосон зээлийн үлдэгдлээс хамгийн өндөр 33.1 хувь буюу 279.2 тэрбум төгрөгийг, ЖДҮ эрхлэгч иргэдийн олгосон зээлийн 45.9

буюу 342.9 тэрбум төгрөгийг худалдааны салбарт олгосон байна.

Зураг 17. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь



ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 16.8 хувь нь чанаргүй зээл болжээ. Салбараар нь авч үзвэл ЖДҮ-ийн зориулалтаар аж ахуйн нэгжид олгосон зээлийн хувьд үйлчилгээний салбарын чанаргүй зээл 26.6 хувь, хөдөө аж ахуйн салбарынх 21.9 хувь, иргэдэд олгосон үйлчилгээний салбарын чанаргүй зээл 21.7 хувь, барилгын салбар 18.1 хувь, боловсруулах үйлдвэрлэл 7.5 хувьтай байна.

Зураг 18. ЖДҮ-ийн зээлийн хүү, хугацаа



ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацааг харьцуулахад иргэдэд олгосон зээл 20.8 хувиас 24.5 хувийн хүүтэй, хугацааны хувьд 7.2 сараас 4.6 жилийн хооронд байгаа бол аж ахуйн нэгжид олгосон зээл 10.6 хувиас 19.6 хувийн хүүтэй, хугацааны хувьд 1.5 жилээс 5.7 жил хүртэл хугацаатай

олгогдсон байна. Харин ЖДҮ эрхлэх зориулалтаар иргэдэд олгосон зээлийн хувьд барилгын салбар хамгийн өндөр хүүтэй буюу 24.5 хувийн хүүтэй 4.6 жилийн хугацаатай олгогджээ.